

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

I. ТӨСӨВ: Аймгийн төсвийн орлогод 4946.8 сая төгрөг орж, төлөвлөгөө нь 13.1 хувиар давж биелсэн байна. Өнгөрсөн оны мөн үеийнхээс 2561.4 сая төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Сумдын төсвийн орлогын төлөвлөгөө 7.4 хувиар давж биелсний дотор Баруун-Урт сумаас бусад бүх сум биелүүлээ.

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилт 3972.9 сая төгрөг болж, төлөвлөгдсөн хэмжээнээс 401.0 сая төгрөгөөр доогуур байна. Наран, Дарьганга, Баруун-Урт, Түмэнцогт сумд 0.3-18.8 хувиар тус тус хэтэрсэн гүйцэтгэлтэй байна.

II. МӨНГӨ, ЗЭЭЛ: Монгол банкны мэдээгээр ХААН, Хадгаламж, Хас банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 15.0 тэрбум төгрөгт хүрсэн нь 2009 оны жилийн эцсээс 2.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Банкуудад хадгалуулсан иргэдийн хадгаламжийн хэмжээ 11.2 тэрбум төгрөг болсон нь 2009 оны жилийн эцсээс 3.8 тэрбум төгрөгөөр өссөн байна. Мөн банкуудын хугацаа хэтэрсэн зээл 0.4 тэрбум төгрөгт хүрсэн байна.

III. ХӨДӨӨ АЖ АХУЙ: Газар тариалан: Тариалалтын эцсийн мэдээгээр үр тариа 80 га-д, төмс 59.0 га-д, хүнсний ногоо 28.0 га-д, тэжээлийн ургамал 94.4 га-д тус тус тариалалт хийгээд байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс үр тарианаас бусад тариалалт дээгүүр гүйцэтгэлтэй байна.

IV. АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 15.7 тэрбум төгрөг болсон нь урьд оны мөн үеийнхээс 2.4 тэрбум төгрөгөөр доогуур байна.

Оны үнээр 62.1 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 1.6 дахин дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлөөс цайрын баяжмал, блок, өнгөт тоосгоны үйлдвэрлэлт доогуур байна.

V. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС: Хэрэглээний үнийн индекс 7-р сард 2009 оны жилийн эцсийнхээс 2.2 хувиар өссөн хэдий ч урьд сарыхаас 2.8 хувиар буурлаа. Энэ нь Хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг, тээврийн бүлгийн үнэ нь 6.0-0.9 хувиар буурсан байна. Хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үний бууралтад хүнсний бараа буюу малын гаралтай түүхий эд болох мах, махан бүтээгдэхүүн, сүүн, сүүн бүтээгдэхүүний үнэ 11.9-16.4 хувиар буурсан гол нөлөөлсөн байна.

VI. ЭРҮҮЛ МЭНД: 671 эх амаржиж, 680 хүүхэд амьд төрсөн байна. 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 18 болж урьд оны мөн үеэс 10-аар олон байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 293 болж, урьд оны мөн үеэс 195-аар доогуур байгаагийн дотор вируст гепатит, салхинцэцэг, тэмбүү, заг, трихоминиаз зэрэг өвчнүүд буурсан байна.

VII. АЖИЛГҮЙЧҮҮД: Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1240 болж, урьд оны мөн үеийнхээс 41 хүнээр нэмэгдсэн байна. Ажилгүйчүүдийн 69.3 хувь нь 16-34 насны залуучууд, 17.9 хувь нь дээд, 3.5 хувь нь тусгай дунд, 36.3 хувь нь бүрэн дунд, 8.1 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна.

1674 хүн шинээр бүртгүүлж, 1415 хүн ажилд орсон байна.

Шинэ ажлын байранд ажиллаж байгаа хүний тоо 363-т хүрчээ.

VIII. ГЭМТ ХЭРЭГ: 104 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 3-аар доогуур байна.

Гэмт хэргийн улмаас 25 хүн нас барж, 20 хүн гэмтэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 76.9 сая төгрөгийн хохирол учирсны 69.4 саяыг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 90 хүн холбогдон сэжиглэгдсэний 16.7 хувь нь согтуугаар, 16.7 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна.

Нийт 1434 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеийнхээс 136 хүнээр доогуур байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 69 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.

Хэрэг илрүүлэлт 100.0 хувьтай байна.

IX. МАЛЫН ИНДЕСЖҮҮЛСЭН ДААТГАЛ ТӨСӨЛ: 2010 онд манай аймагт МИД төслийг хэрэгжүүлэх эрх авсан 4 даатгалын компанийн төлөөлөгчид 13 сумын 649 малчны 119.1 мянган малыг даатгалд хамруулан, 51.6 сая төгрөгийн хураамжийг МИД төслийн нэгжийн дансанд төвлөрүүлсэн байна.

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооноос гаргасан 2010 оны хагас жилийн мал тооллогын дүнг үндэслэн Малын индексжүүлсэн даатгал мөсөл хэрэгжүүлэх нэгж төслийн удирдах хорооноос гаргасан шийдвэрийн дагуу Сүхбаатар аймгийн хувьд Түмэнцогт, Сүхбаатар, Эрдэнэцагаан сумдын 44 өрхөд нөхөн төлбөр авахаар боллоо.